



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/13

Мандалговь

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай
зөвшөөрөл хүчингүй болгох тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.20.1, 19.20.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох салбар комиссын 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хавсралтад зааснаар хүчингүй болгосугай.

Хоёр. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг тусгай зөвшөөрөл олгох салбар комисс (А.Нарантуяа), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Эрүүл мэндийн газар (Г.Бат-Орших)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

481210018

Аймгийн Засаг даргын 2021 оны 01-р сарын 11-ны өдрийн 1/дугаар захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ

№	Үүсгэн байгуулагчийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар
1	"Дэлгэрийн чойр түмний шүтээн" ХХК	"Энэрэл" сувилал	Сувиллын мэргэжлийн үйл ажиллагаа	СХ-16/10/1033
2	"Болорбадмаараг" ХХК	"Принцесс" хүүхдийн эмнэлэг	Хүүхдийн өвчний оношилгоо, эмчилгээ	ЭХ-15/10/1034
3	"СОСУ" ХХК	"СОСУ" ариутгал халдваргүйтгэл	Ахуйн шавьж, мэрэгч устгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ	АҮХ-17/10/1038